



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**


**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ДАЛАЙН ЗАХИРГАА**



**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН АЛС ДОРНОДЫН БҮС НУТГИЙН ДАЛАЙН БООМТУУД
БОЛОН ТЭДГЭЭРИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

**Улаанбаатар хот
2017 он**

2.2.1. ВАНИНО ДАЛАЙН ХУДАЛДААНЫ БООМТ



Боомтын байршил: Тус боомт нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 4273 км зайд оршдог, Алс Дорнод дахь далайн боомтуудын 5-дугаарт, ОХУ-ын хэмжээнд 10 дугаарт ордог томоохон боомт бөгөөд Байгаль-Амарын төмөр замын төгсгөлийн цэг юм. Хөлөг онгоцны хөдөлгөөн жилийн турш үргэлжлэх ба өвлийн цагт /1-3 сар/ мөс зүсэгч хөлөг онгоцны тусламжтайгаар явагддаг.

Боомтын эзэмшигч:

Ванин

682860, Хабаровский край,

п. Ванино, ул. Железнодорожная, д.2

Тел./факс: +7 (42137) 7-67-79, 7-66-01

E-mail: ampvanino@ampvanino.ru

Оператор компани: *Vanino Comercial Sea Port XK*

Ачаа эргэлт: Тус боомтын ачаа эргэлт 2014 онд 26.2 сая тонн, 2015 онд 26.9 сая тонн ачаа боловсруулсан.

Далайн тээврийн сүлжээ: Ванино боомт нь Ази-Номхон далайн бүсийн орнууд болон, Япон, Австрали, АНУ, БНАСАУ болон БНХАУ-аас голчлон ачаа хүлээж авч, тээвэрлэдэг байна.

Төрөлжсөн байдал : Газрын тос, чингэлэг тээвэр, мод, төмөр, нүүрс.

Боомтын хүчин чадал: Жилдээ 12 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай. Боомтын хэмжээнд нийт 16 хөлөг онгоцны зогсоолтой. Боомт нь 220 м хүртэл урттай, 11 м хүртэл суулт бүхий хуурай ачааны хөлөг онгоц, 13.5 м хүртэл суулттай газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцуудыг хүлээн авч ачилт, буулгалт хийдэг. Ачааны 20 хөлөг онгоцны зогсоолтой, зогсоол тус бүр 9-11м гүнтэй 45 мянган тонн хүртэлх даацтай хөлөг онгоц хүлээж авах хүчин чадалтай. Ачилт буулгалтын 4 цогцолбор, газрын тос тээвэрлэх зогсоолтой.

Ачих буулгах нэгдүгээр цогцолбор нь ачааны 4 зогсоол, 1 тавцантай, зогсоолын нийт урт 660м, усны гүн 10.5м. Нийт боомтын 14 өргөгч цамхагтай.

Ачих буулгах хоёрдугаар цогцолбор нь ачааны 4 зогсоол, 1 тавцантай, зогсоолын нийт урт 776м, усны гүн 11.5м. Нийт боомтын 7 өргөгч цамхагтай.


Ачих буулгах гуравдугаар цогцолбор нь ачааны 6 зогсоолтой, зогсоолын нийт урт 920м, усны гүн 10-11.5м, боомтын 18 өргөгч цамхагтай.

Ачих буулгах дөрөвдүгээр цогцолбор нь Ванино болон Сахалины хооронд хийгдэж буй төмөр зам, далайн тээвэрлэлтийн үйлчилгээг гүйцэтгэдэг, жилдээ 5.6 сая тонн ачаа боловсруулалт хийгддэг.

Газрын тос тээвэрлэх терминал нь тус бүр нь 40,70, 80м-ийн урт бүхий 3 зогсоолтой, усны гүн 7.5-15м хүрдэг. Иймээс 100 тонн хүртэлх даацтай газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцуудыг хүлээн авах боломжтой. Энэхүү терминал нь жилд 3 сая хүртэл тонн газрын тосны бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадалтай.

Онцлог давуу тал: Боомт нь төрөл бүрийн зориулалттай өөрийн 20 гаруй хөлөг онгоцтой. Тус боомт нь 2010 онд 6,011 сая тонн ачаа боловсруулан, 2010 оны эхний 9 сард 1,037 тэрбум рублийн борлуулалт хийж, 92 сая рублийн цэвэр ашиг олсон ба түүний хувьцааны улсын мэдэлд байсан 73 хувийг дуудлага худалдаагаар “Сельтехстрой” компани авчээ.

2.2.2 ВОСТОЧНЫЙ ДАЛАЙН БООМТ



Боомтын байршил: Япон тэнгисийн Находкийн буланд Врангелийн хоолойд оршдог далайн боомт юм. Номхон далай дахь ОХУ-ын тээврийн «Восточный-Находка» гэсэн томоохон зангилаанд ордог. Транссибирийн төмөр замын магистралийн төгсгөл, Находка хотоос 20 км зайд байрладаг.

Боомтын эзэмшигч:

Восточный порт ХК
Vnutriportovaya, 47Nakhodka, Vrangal,
Primorsky Region 692941, Russia
Тел./факс: 7 (4236) 665 271
E-mail: vp@vpnet.ru

Боомтын менежментийг “Port Management LLC” удирдаж авч явдаг.

Ачаа эргэлт: 2011 оны байдлаар 38,4 сая тонн, 2014 онд 57.8 сая тонн, 2016 онд 65.2 сая тонн ачаа боловсруулсан ба мөн онд 23.5 сая тонн нүүрс боловсруулан тээвэрлэсэн үзүүлэлтээрээ Оросын нүүрсний ачаа эргэлтийн 19 хувийг эзэлсэн.

Далайн тээврийн сүлжээ: Нийт боловсруулсан бараа бүтээгдэхүүний 99 хувийг Номхон далайн бүсийн орнууд болох Өмнөд Солонгос, Япон, Хятад руу тээвэрлэгддэг.

Нүүрс экспортлодог улсууд: Өмнөд Солонгос (41%), Япон (26%), БНХАУ (11%), Малайз (7%), Тайван (5%), Вьетнам (5%), Энэтхэг (2%).

Төрөлжсөн байдал: Нүүрс, нефть, контейнер тээвэрлэлт, автомашин

Боомтын хүчин чадал: Боомтын усны гүн 22м ба 180 мянган тонны даацтай хөлөг онгоц хүлээж авах хүчин чадалтай. Восточный боомт нь дотроо ерөнхий ачаа тээвэрлэх цогцолбор, нүүрсний төрөлжсөн цогцолбор, боомт хэсэг үндсэндээ хуваагддаг байна.

Ачаа боловсруулах терминалын хүчин чадал жилд 63,796 мян.тонн, үүнээс шингэн ачаа 31,788 мян.тонн, хуурай ачаа 24,172 мян.тонн, чингэлэг 653 мян.ТЕU.

Ачаа задгайгаар хадгалах талбай 457.53 мян.м², ачаа битүү хадгалах 34.69 мян.м², нефть хадгалах емкость 28 мян.тонн багтаамжтай.

Онцлог давуу тал: Боомт барих газрыг 1968 онд сонгож, 1970 онд барилгын ажил эхэлж, 15 км-ийн урттай 64 зогсоол, 50 мянган оршин суугчидтай дагуул хот байгуулах, боомтын ачаа эргэлт 40 сая тонн байхаар төлөвлөж байв. Контейнерын зогсоолыг 1976 онд барьж ашиглалтад оруулсан. Нефть шатахууны тусгай боомтыг 2009 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин албан ёсоор нээсэн байна.

Восточный боомт нь нүүрсний тээврийн төрөлжсөн хоёр цогцолбор талбайтай. Нэгдүгээр цогцолбор нь нүүрсийг машинаас вагонд конвероор шилжүүлэн ачих 98.9 хувийн бүрэн автоматжуулалттай талбай юм. Уг талбайгаар 2016 онд жилдээ 17.8 мян.тонн нүүрс шилжүүлж ачсан. Хоёрдугаар цогцолбор нь нүүрсийг кранаар(шанагатай) шилжүүлэн ачилт хийгддэг талбай ба 2016 онд 5.7 мян.тонн нүүрсийг шилжүүлж ачсан байна.

2012 онд 54 га талбайд орчин үеийн бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон нүүрсний төрөлжсөн гуравдугаар цогцолбор төслийн барилгын ажлыг эхлүүлсэн ба энэ нь нүүрсийг төмөр замаас хөлөг онгоцонд шилжүүлж ачих зориулалттай юм.


Хүснэгт. Боомтод үйл ажиллагаа явуулдаг компаниудын мэдээлэл

№	Оператор компани	Терминал	Зогсоол №	Зогсоолын урт /метр/	Нийт талбай /га/	Ачаа боловсруулах хүчин чадал /Жилд, мян.тонн/	Ачаа хадгалах талбай /мян.м2/
1	ОАО «Восточный порт»	Универсал терминал	11, 12, 13, 14,	779.9	23.89	3500	107.1 /Задгай/
2	ОАО «Восточный порт»	Боомтын үйлчилгээний хөлөг онгоцны терминал	30,	80,25	0,157	-	-
3	ОАО «Восточный порт»	Нүүрс боловсруулах терминал	49, 50,	762.8	44.9	14200	120 /Задгай/
4	ООО «Восточный лесной порт»	Универсал терминал	31, 32,	300	11	368	10,5 /Задгай/
5	ООО «Малый порт»	Универсал терминал	33, 34, 35,	353.3	3.06	2540	19.3 /Задгай/
6	ООО «Восточная стивидорная компания»	Контейнерын терминал	5, 6, 7, 8,	1284	72	8800	190 /Задгай/ 14.2 /Хаалттай/
7	ООО «Восточный нефтехимический терминал»	Нефть болон химийн бүтээгдэхүүний терминал	39	206	4.4	1300	0.028 мян.тоннын емкость
8	ЗАО «Топливоно бункерная компания»	Х.О-ны шатахуун цэнэглэх терминал	9	60	0.21	488	-
9	ООО «Восточно Уральский терминал»	Ачаа ачих, шилжүүлэх	10	218	10.9	2500	7.14 /Задгай/ 20 /Хаалттай/
10	«Росморпорт»	Х.О-нд үйлчилгээ үзүүлэх зогсоол	29	138.5	0.6	-	-
11	ООО«Специализированный морской нефтеналивной порт Козьмино»	Нефтепирс	1, 2,	298	0.596	-	0.49 /Задгай/

Монгол Улсын хилийн боомтоос Ванино боомт хүртэлх төмөр замын тээврийн зай:

- Наушки-Восточный далайн боомт хүртэл 4047 км
- Эрээнцав-Восточный далайн боомт хүртэл 3483 км

2.2.3 ВЛАДИВОСТОКИЙН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ БООМТ



Боомтын байршил: Тус боомт нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 4200 км зайд оршдог бөгөөд Владивосток хотын баруун хойд эрэг Алтан эвэр хэмээх үл хөлдөх тэнгисийн буланд байрладаг.

Боомтын эзэмшигч: Фэско тээврийн групп (FESCO transportation group)

Address:

Commercial Port of Vladivostok
9, Strelnikov Str.,
Vladivostok, Primorsky Krai,
690065 Russia

Phones:

(423) 249-73-56
Fax: (423) 249-73-56, 249-52-76
E-mail: vmtp@fesco.com

Оператор компани: *Commercial Port of Vladivostok*

9, Strelnikov str., Vladivostok, 690950,

Russia Tel: +7 (423) 2495-169, 2495-173

Fax: +7 (423) 2495-276

E-mail: market@vmtp.ru

Website: <http://www.vmtp.ru>

Ачаа эргэлт: Тус боомт нь жилдээ 11 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай.

Жилийн нийт ачаа эргэлт 2012 онд 6.6 сая тонн, 2013 онд 5.8 сая тонн, 2014 онд 6.2 сая тонн байсан бол 2015 онд 5 сая тонн буюу өмнөх оноос даруй 20 хувийн бууралтийг үзүүлсэн бол 2016 онд 5.6 сая тонн болж өссөн үзүүлэлттэй байна. Чингэлэгийн жилийн нийт ачаа эргэлт 2014 онд 513 мянган TEU болж дээд хэмжээндээ хүрч байсан бол 2015 онд 345 мянган TEU, 2016 онд 330 мянган TEU болж тус тус буурсан үзүүлэлттэй байв.

Төрөлжсөн байдал:

Импорт: ерөнхий ачаа, төмрийн бэлдэц, үр тариа, хүдэр, мод, зүсмэл модон материалууд.

Экспорт: түүхий газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, үр тариа, тэжээл, ерөнхий ачаа.

Далайн тээврийн сүлжээ: Ази-Номхон далайн бүс нутаг дахь тус боомтын газар зүйн ашигтай байрлал нь боомтын ачаа урсгалын чиглэлийг тодорхойлдог бөгөөд дамжуулан тээвэрлэх ачааны урсгал Өмнөд Солонгос, Япон, Хятад, Тайвань, Тайланд, Вьетнам руу чиглэдэг. Мөн ОХУ-ын дотоодын ачааны урсгалыг Петропавловск-Камчатск, Магадан, Анадырь, Корсаков болон Чукоткын автономит тойргийн боомтуудад хүргэдэг.

Боомтын хүчин чадал: Владивостокийн далайн худалдааны боомт нь 14 хөлөг онгоцны зогсоолтой.



№ 03-13 — Ерөнхий ачаа, автомашин, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, газрын тос, чингэлэгийн талбай. (№11 — Газрын тос ачиж буулгах зориулалттай зогсоол)

албайн хэмжээ: 231,159 м.кв

итүү агуулах: 47,126 м.кв

огсоолын эргийн урт 2.1км

огсоолын усны гүн: 10-15м

Жилийн нэвтрүүлэх хүчин чадал:

80 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн

амгийн багадаа 2 сая тонн ерөнхий ачаа

№ 14-16 — Чингэлэгийн зориулалттай терминаль

- Талбайн хэмжээ: 278 мянган м.кв

- Зогсоолын нийт урт: 741м

- Зогсоолын усны гүн: 12-14м

- Талбайн багтаамж: 13,000TEU

- 600 хөлдөөгчтэй чингэлэг (нэг удаад 426 чингэлэг зэрэг тогонд холбох боломжтой)

Жилийн нэвтрүүлэх хүчин чадал:

- 600 мянган TEU

Тоног төхөөрөмж: Ачаа боловсруулах тоног төхөөрөмжийн тоо 160 гаруй, үүнээс 63 тоннын даацтай таван кран, 100 тоннын даацтай нэг крантай.

Онцлог давуу тал: Владивосток боомтод хөдөлгөөн бүтэн жилийн турш үргэлжилдэг.


Гадаад худалдааны үйл ажиллагаа нь 1991 оноос хойш нээлттэй болсноос хойш Владивостокийн далайн худалдааны боомт нь экспорт-импортын ачаа эргэлтийн хүчин чадлаа байнга нэмэгдүүлж, дэд бүтцээ барьж байгуулж байгаа. Ингэснээр ОХУ-ын Алс Дорнодын бүс

нутгаар дайран өнгөрч буй ачааны урсгалыг нэвтрүүлэх, үйлчилгээний өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх боломжтой болж байна.

Монгол Улсын хилийн боомтоос Владивосток боомт хүртэлх төмөр замын тээврийн зай:

- Наушки- Владивосток далайн худалдааны боомт хүртэл 3895 км
- Эрээнцав- Владивосток далайн худалдааны боомт хүртэл 3331 км

2.2.4 ЗАРУБИНО ДАЛАЙН ХУДАЛДААНЫ БООМТ



Боомтын байршил: БНХАУ-тай 18 км зайд төмөр зам, автозамаар Хунчунаар холбогддог, Владивосток боомтоос 210 км зайд, БНАСАУ-тай хамгийн ойр байрладаг, хөлөг онгоцны хөдөлгөөн бүтэн жилийн турш үргэлжилдэг бөгөөд 1973 онд байгуулагдсан боомт юм.

Боомтын эзэмшигч: Сумма Групп

Ачаа эргэлт: «Тройцийн булан дахь Тэнгисийн боомт» нээлттэй хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Универсал Зогсоолын ачаа боловсруулах хүчин чадал жилд 1,2 сая тонн.

Загас агнуурын хөлөг онгоцны "Зарубины флотын бааз" ХНН-ийн цогц терминалын жилд 2 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай 3 зогсоолтой.

Далайн тээврийн сүлжээ: БНХАУ болон БНСУ-ын хооронд транзит, контейнер тээвэр хийж, автомашин бусад техник хэрэгсэл ба загасан бүтээгдэхүүн, экспортолж, импортолдог.

Төрөлжсөн байдал: Контейнер тээвэр, автомашин, техник тоног төхөөрөмж, загас, транзит ачаа.

Онцлог давуу тал: «Тройцийн булан дахь Тэнгисийн боомт» нээлттэй хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Универсал терминалын нийт талбай - 29.8 га, задгай ачаа агуулах талбай- 17.85 мян.м2, битүү агуулахын талбай - 17.15 мян.м2, хөлөг онгоцны 4 зогсоолтой, зогсоолын нийт


урт нь 650 м. 130 м хүртэл урт, 17 м өргөнтэй, 7,3 м хүртэл метр суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай.

Загас агнуурын хөлөг онгоцны "Зарубины флотын бааз" ХХН-ийн цогц терминалын нийт талбай - 9.4 га, задгай ачаа агуулах талбай- 2 мян.м2, ачааг битүү хадгалах талбай - 9.23 мян.м2, нийт урт нь 191 м болно. 100м хүртэл урт, 15м өргөнтэй, 5 м хүртэл суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай.

Монгол Улсын хилийн боомтоос Ванино боомт хүртэлх төмөр замын тээврийн зай:

- Наушки-Зарубино далайн боомт хүртэл 4026 км
- Эрээнцав-Зарубино далайн боомт хүртэл 3476 км

2.2.5 ПОСЬЕТ ДАЛАЙН БООМТ



Боомтын байршил: БНАСАУ-тай хамгийн ойр хиллэдэг далайн боомт юм.

Боомтын эзэмшигч: «Посьетийн худалдааны боомт» нээлттэй хувь нийлүүлсэн нийгэмлэг, «Славяны хөлөг онгоц засварын завод» үйлдвэрлэлийн хувь нийлүүлсэн нийгэмлэг, «Дорнын бункер» Хаалттай хувь нийлүүлсэн нийгэмлэг, «Славяны модны терминал» ХНН

Ачаа эргэлт: Ачаа, бараа боловсруулах терминалын хүчин чадал жилдээ 3614 мян.тонн, үүнээс шингэн ачаа - 450 мян.тонн, хуурай ачаа – 3063 мян.тонн, контейнер - 8.4 мян TEU болно.

Далайн тээврийн сүлжээ: Ази- Номхон далайн бүс нутгийг экспорт, импорт мөн транзит тээврийн бараа бүтээгдэхүүн болон нүүрсээр хангадаг.

Төрөлжсөн байдал: Нүүрс, нефть, контейнер тээвэр

Онцлог давуу тал: Улирлын чанартай 4-11 сарын хооронд үйл ажиллагаа явуулдаг.

«Посьетийн худалдааны боомт» нээлттэй хувь нийлүүлсэн нийгэмлэгийн универсал терминалын нийт талбай - 16.75 га, ачаа хадгалах задгай талбай- 34.68 мян.м2, жилдээ 2500

мян.тонн ачаа боловсруулах хүчин чадалтай 3 зогсоолтой. Зогсоолын нийт урт нь 440м. 175м хүртэл урттай, 26м хүртэл өргөн, 9 хүртэл м-ийн суулттай хөлөг онгоц хүлээн авах боломжтой.

«Славяны хөлөг онгоц засварын завод» үйлдвэрлэлийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийн нийт талбай - 41.73 га, задгай ачаа агуулах талбай- 42.79 мян.м², ачааг битүү хадгалах талбай - 26.88 мян.м², жилд 422 мян.тонн ачаа боловсруулах хүчин чадалтай 4 зогсоолтой. Зогсоолын нийт урт - 1060.5 м. 150 м урт, 15м өргөн, 8 м хүртэлх суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай.

«Дорнын бункер» Хаалттай хувь нийлүүлсэн нийгэмлэгийн нефтийн терминалын нийт талбай - 9.94 га, нефть, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис - 40.66 мян.тонныг агуулах савтай. Жилд 450 мян.тонн ачаа боловсруулах хүчин чадалтай, 4 зогсоолтой. Зогсоолын нийт урт - 638 м. 183м хүртэл урт, 32м хүртэл өргөн, 8м хүртэл суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай.

«Славяны модны терминал» ХНН -ийн Универсал терминалын нийт талбай - 4.8 га, ачаа хадгалах задгай талбай - 27мян.м², ачааг хадгалах битүү талбай - 3.16 мян.м², жилд 238 мян.тонн ачаа боловсруулах хүчин чадалтай. 130м-ийн урттай 1 зогсоолтой. 139м хүртэл урт, 16м хүртэл өргөн, 4,5 м хүртэл суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай.

«Далайн хав» ХНН-ийн Загас агнуурын хөлөг онгоцны цогц, холимог терминалын нийт талбай - 8.8 га, ачаа хадгалах задгай талбай - 2.7 мян.м². Жилдээ 4 мян.тонн ачаа боловсруулах хүчин чадалтай, нийт урт нь 140м бүхий 4 зогсоолтой. 60м хүртэл урт, 8м хүртэл өргөн, 8 м хүртэл суулттай хөлөг онгоц хүлээн авах хүчин чадалтай. Боомтын үйл ажиллагаа жил бүрийн 4-өөс 11 сарын хооронд явагддаг.